



ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 19/08

Улаанбаатар хот

Сайжруулсан түлшний тээвэрлэлт, борлуулалтын тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны “Үндэсний хорооны ажиллах журмыг шинэчлэх тухай” 19/04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Орчны бохирдлын Үндэсний хорооноос ТОГТООХ НЬ:

1. Улаанбаатар хотын зүүн хагасыг сайжруулсан шахмал түлшээр хангах зорилгоор борлуулалтын нэмэлт цэг байгуулах, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Таван толгой түлш” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Ганбаатар/-т, тухайн цэг рүү Толгойт, Амгалан чиглэлд төмөр замаар сайжруулсан түлш тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд /Л.Халтар/-т тус тус даалгасгай.
2. Борлуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн боловсруулж 2019 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн дотор батлуулж ажиллахыг Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Амарсайхан/, Таван толгой түлш ХХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Ганбаатар/ нарт даалгасгай.
3. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Гантулга/-д даалгасгай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ